



# GOBI

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

## “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

*Компанийн өөрийн үнэлгээ  
(Санхүүгийн Зохицуулах Хороо  
хянан баталгаажуулсан)*

Улаанбаатар хот

2025 оны 06-р сарын 30

[info.gobi.mn](http://info.gobi.mn)

**АГУУЛГА**

❖ Үнэлгээний аргачлал . . . . .	3
❖ Үнэлгээний нэгдсэн дүн . . . . .	4
❖ Үнэлгээний дэлгэрэнгүй тайлан . . . . .	5
❖ Нотлох баримтын жагсаалт . . . . .	21

## ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж”-ийн үнэлгээний аргачлалын дагуу Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг 2025 оны 06-р сарын 30-ны өдрийн байдлаар ТУЗ-ийн ажлын алба үнэлж, Санхүүгийн зохицуулах хороо хянан баталгаажуулсан болно.

### Үнэлгээний асуулгын бүтэц

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг
3. Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал
4. Аудит, хяналтын тогтолцоо
5. Эрсдэлийн удирдлага
6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал
7. Оролцогч талуудын эрх ашиг
8. Компанийн соёл
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх гэсэн 9 үндсэн үзүүлэлт бүхий нийт 36 асуулгаас бүрдсэн.

### Үнэлгээний оноо

Асуулга тус бүрийн хүрээнд хийгдвэл зохих ажлын хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж түүнийгээ хувьд шилжүүлэн, үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно.

- Бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо;
- Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1 оноо;
- Хэрэгжүүлээгүй, үнэлгээ ирүүлээгүй бол 0 оноо.

### Нэгдсэн үнэлгээ

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ.

- Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул Монголын хөрөнгийн биржээс зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул Монголын хөрөнгийн биржээс зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзнэ.

## ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

Хүснэгт 1. Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний нэгдсэн дүн

№	Гарчиг	Авбал зохи оноо	2025.12.31-ний байдлаар		2025.06.30-ны байдлаар			Өөрчлөлт хувь
			СЗХ-ны хяналтын оноо	Хувь	Өөрийн үнэлгээний оноо	СЗХ-ны хяналтын оноо	Хувь	
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100.0%	11	11	91.7%	-
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100.0%	9	9	90.0%	-10.0%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100.0%	6	6	100.0%	-
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100.0%	6	6	100.0%	-
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100.0%	8	8	100.0%	-
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100.0%	6	6	100.0%	-
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100.0%	8	8	100.0%	-
8	Компанийн соёл	6	6	100.0%	6	6	100.0%	-
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90.0%	10	10	100.0%	10.0%
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>72</b>	<b>71</b>	<b>98.6%</b>	<b>71</b>	<b>71</b>	<b>98.6%</b>	<b>71</b>

Хүснэгт 1-д үзүүлсэн нэгдсэн дүнгээс харахад Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээг 2024 оны эцсийн байдлаар Санхүүгийн Зохицуулах Хороогоор хянан баталгаажуулалт хийлгэхэд 98.6% буюу засаглал хэвийн, эрсдэлгүй гэж үнэлэгдсэн.

Харин 2025 оны эхний хагас жилийн байдлаар өөрийн үнэлгээг хийхэд 98.6% буюу өмнөх жилийн эцсээс өөрчлөлтгүй үр дүнтэй гарсан.

## ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Хүснэгт 2. Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний дэлгэрэнгүй тайлан

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	<b>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК-ийн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам” болон “ТУЗ-ийн ажлын албаны журам”-д ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг хариуцлагыг нарийвчлан тусгасан. <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">ТУЗ-ийн үйл ажиллагааны журам</a></li> <li>• <a href="#">ТУЗ-ийн ажлын албаны журам</a></li> <li>• <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a>-ийн 86-87-р нүүрэнд ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг тусгасан.</li> </ul>	2	100%
2	<b>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь ТУЗ-өөс баталсан “ЭБАТ-уудын залгамж халааны бодлого”, “ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам”-тай ба хэрэгжилтийг нь ханган ажилладаг. Мөн Нэр дэвшүүлэх хорооноос “ТУЗ-ийн гишүүдийн санамж бичиг”, “Нууц хадгалах гэрээний загвар”-ыг баталсан бөгөөд шинээр томилогдсон гишүүдтэй санамж бичиг, нууц хадгалах гэрээ байгуулдаг. <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">ЭБАТ-уудын залгамж халааны бодлого</a></li> <li>• <a href="#">ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам</a></li> </ul>	2	100%
3	<b>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Жилийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн гишүүдийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц, цалин урамшуулал зэрэг холбогдох	2	100%

	<b>эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</b>		<p>мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар тусгадаг бөгөөд компанийн цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Бид ТУЗ-ийн болон ТУЗ-ийн гишүүний өөрийн үнэлгээг жил бүр хийн Нэр дэвшүүлэх хорооны хурал дээр хэлэлцэж, жилийн тайланд үр дүнгээ тусгадаг.</p> <p>Мөн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь ажлын үр дүнгээ жилийн тайланд тусгаж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр тайлагнадаг.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a>-ийн 80-84-р нүүрэнд ТУЗ-ийн гишүүдтэй холбоотой мэдээллийг тусгасан. 88-89-р нүүрэнд ТУЗ болон ТУЗ-ийн гишүүний үнэлгээний үр дүнг тусгасан.</li> <li>• <a href="#">Компанийн цахим хуудас</a> дахь ТУЗ-ийн гишүүдтэй холбоотой мэдээлэл</li> </ul>		
4	<b>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>“ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д ТУЗ болон хороодын бүтэц бүрэлдэхүүн, хүйсийн тэнцвэрт байдал зэрэгтэй холбоотой заалтыг оруулсан байдаг.</p> <p>“ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам”-д ТУЗ-ийн гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлагыг тусган оруулсан.</p> <p>“ТУЗ-ийн ажлын албаны журам”-д ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон ТУЗ-ийн мэргэжилтэнд тавигдах шаардлагыг тусган оруулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">ТУЗ-ийн үйл ажиллагааны журам</a></li> <li>• <a href="#">ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам</a></li> <li>• <a href="#">ТУЗ-ийн ажлын албаны журам</a></li> </ul>	2	100%
5	<b>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход ТУЗ-ийн ажлын албанаас компанийн болон ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой чиглүүлэх танилцуулгыг хийдэг.</p> <p>Мөн ТУЗ-ийн гишүүнд зориулсан гарын авлагыг боловсруулж, агуулгыг нь тогтмол шинэчилдэг.</p>	2	100%

	<b>чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</b>		Нэр дэвшүүлэх хорооны зүгээс гишүүддээ ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг мэдээллийг олгох сургалтын хэрэгцээг тодорхойлон, жил бүрийн эхэнд ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган оруулж компанийн зардлаар хамруулдаг. <b>Хавсралт: 2025 оны ТУЗ-ийн сургалтын төлөвлөгөөний биелэлтийн тайлан</b>		
6	<b>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь ТУЗ-ийн ажлын албатай бөгөөд “ТУЗ-ийн ажлын албаны журам”-аар үйл ажиллагааг нь зохицуулдаг. ТУЗ-ийн ажлын албаны бүрэлдэхүүн болох ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон мэргэжилтнийг ТУЗ-өөс томилдог бөгөөд ТУЗ-ийн дарга шууд чиглүүлгээр ханган ажилладаг. ТУЗ-ийн ажлын алба нь ажлын үр дүнгээ ТУЗ-ийн дарга болон ТУЗ-д тайлагнадаг. • <a href="#">ТУЗ-ийн ажлын албаны журам</a>	2	100%
ДҮН (Авбал зохих оноо-12)				12	100%
<b>ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b> ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	<b>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь “Засаглалын бодлого” болон “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-даа ТУЗ-ийн дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорих тухай тусгасан байдаг. Одоо ТУЗ-ийн даргаар ердийн гишүүн харин ТУЗ-ийн дэргэдэх хороодын даргаар хараат бус гишүүн томилогдон ажиллаж байна. • <a href="#">Засаглалын бодлого</a> • <a href="#">ТУЗ-ийн үйл ажиллагааны журам</a> • <a href="#">2025 оны ХЭХ-ын тогтоол</a> • <a href="#">ТУЗ-ийн дарга болон хороодын бүрэлэхүүнийг томилсон тухай ТУЗ-ийн тогтоол</a>	1	50%

8	<p><b>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь үйл ажиллагааны журамтай. Мөн 2021 онд Дотоод хяналтын бодлогын баримт бичгийг боловсруулан ТУЗ-өөр батлуулсан. Тус хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн томилогдон ажиллаж байна.</p> <p>Эрсдэл, аудитын хороо нь улирал тутам хуралдан компанийн санхүүгийн тайлагнал, дотоод аудит, комплайнс, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг бөгөөд хурлын хэлэлцэх асуудлын дагуу хорооны хүсэлтээр холбогдох удирдлагууд хуралд оролцдог.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Эрсдэл, аудитын хорооны үйл ажиллагааны журам</a></li> <li>• <a href="#">Дотоод хяналтын бодлого</a></li> <li>• <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a>-ийн 94-р нүүрэнд Эрсдэл, аудитын хорооны 2024 оны ажлын тайланг тусгасан.</li> <li>• <a href="#">ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн томилсон ТУЗ-ийн тогтоол</a></li> </ul>	2	100%
9	<p><b>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо нь үйл ажиллагааны журамтай. Мөн 2024 онд компанийн Цалин урамшууллын бодлогыг шинэчлэн ТУЗ-өөр батлуулсан. Тус хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн томилогдон ажиллаж байна.</p> <p>Цалин урамшууллын хороо нь хагас жил тутам хуралдан компанийн цалин урамшууллын тогтолцоо, түүний үр дүнтэй байдал, цалин урамшууллын гүйцэтгэл, компанийн соёлын судалгааны үр дүнд хяналт тавьж ажилладаг бөгөөд хурлын хэлэлцэх асуудлын дагуу хорооны хүсэлтээр холбогдох удирдлагууд хуралд оролцдог.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам</a></li> <li>• <a href="#">Цалин урамшууллын бодлого</a></li> <li>• <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a>-ийн 92-р нүүрэнд Цалин</li> </ul>	2	100%



			<p>урамшууллын хорооны 2024 оны ажлын тайлан, 93-р нүүрэнд Цалин урамшууллын бодлогыг тусгасан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн томилсон ТУЗ-ийн тогтоол</a></li> </ul>		
10	<p><b>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журамтай. Мөн 2023 онд ЭБАТ-уудын залгамж халааны бодлогыг боловсруулан ТУЗ-өөр батлуулсан.</p> <p>Тус хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн томилогдон ажиллаж байна.</p> <p>Нэр дэвшүүлэх хороо нь хагас жил тутам хуралдан компанийн удирдлагын багийн ажлын тайлантай танилцан дүгнэлт өгч, компанийн ТУЗ-ийн өөрийн үнэлгээ, ТУЗ-ийн гишүүний өөрийн үнэлгээ, засаглалын үнэлгээг хэлэлцэн хяналт тавьж ажилладаг бөгөөд хурлын хэлэлцэх асуудлын дагуу хорооны хүсэлтээр холбогдох удирдлагууд хуралд оролцдог.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам</a></li> <li>• <a href="#">ЭБАТ-уудын залгамж халааны бодлого</a></li> <li>• <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан-ийн 90-р нүүрэнд Нэр дэвшүүлэх хорооны 2024 оны ажлын тайлан, 91-р нүүрэнд ЭБАТ-уудын залгамж халааны бодлогыг тусгасан.</a></li> <li>• <a href="#">ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн томилсон ТУЗ-ийн тогтоол</a></li> </ul>	2	100%
11	<p><b>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болох тухай “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д тусгасан байдаг.</p> <p>Компанийн үйл ажиллагааны онцлогоос хамааран 2016 онд ТУЗ-ийн шийдвэрээр Аудитын хороог Эрсдэл, аудитын хороо болгон чиг үүргийн хүрээг нь илүү өргөн болгосон бөгөөд тус хороо нь давхар комплайнсын хяналтыг чиг удирдлагаар ханган ажилладаг.</p>	2	100%

	<i>мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</i>		Мөн 2025 онд БОНЗ-ын хороотой болохоор төлөвлөж байна. <a href="#">ТУЗ-ийн үйл ажиллагааны журам</a>		
ДҮН (Авбал зохих оноо-10)				9	90%
<b>ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b>					
<b>ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана</b>					
12	<b>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-өөс “Олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ыг баталсан. Энэхүү журмын хэрэгжилтийг ханган олон нийтэд хүргэх хугацаат болон тухай бүр мэдээлэх мэдээллийг МХБ болон компанийн цахим хуудас ( <a href="http://info.gobi.mn">info.gobi.mn</a> )-аар дамжуулан тогтмол мэдээлдэг ба хэрэгжилтэд ТУЗ хяналт тавин ажилладаг. • <a href="#">Олон нийтэд хүргэх мэдээллийн журам</a>	2	100%
13	<b>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компанийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, олон нийтэд зориулан компанийн санхүү, үйл ажиллагаа болон засаглалтай холбоотой мэдээ мэдээллүүд (санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан, засаглалын үнэлгээний үр дүн, бодлогын баримт бичгүүд, үйл ажиллагаатай холбоотой шинэ мэдээ, мэдэгдэл)-ийг тогтмол шинэчлэн хүргэдэг. 2024 оноос дээрх мэдээллийг давхар англи хэл дээр хүргэж байгаа. • <a href="#">Компанийн цахим хуудас дахь дүрэм журмууд</a> • <a href="#">Компанийн цахим хуудас дахь тайлан, үзүүлэлтүүд</a>	2	100%
14	<b>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК-ийн ТУЗ болон удирдлагын баг нь компанийн үйл ажиллагааны тайлангийн агуулгаа жил бүр сайжруулан ажилладаг. Бид санхүүгийн тоон үзүүлэлтийг хүн бүрт ойлгомжтой байлгах зорилгоор нэмэлт график, тайлбартай оруулахаас гадна хөндлөнгийн аудитын дүгнэлт, тодруулгыг бүрэн эхээр нь хавсарган оруулж санхүүгийн ил тод байдлыг хангадаг. Харин санхүүгийн бус тайлагналын хувьд борлуулалтын зах зээл тус	2	100%

	<b>нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</b>		бүрийн дэлгэрэнгүй мэдээлэл, үйлдвэрлэл дизайн, бүтээгдэхүүн хөгжүүлэлт гэх мэт компанийн үйл ажиллагааны үр дүн, тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгмийн хариуцлага, засаглал, ТУЗ-ийн үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага зэрэг агуулгаар мэдээлэл бэлтгэн оруулдаг. Мөн эдгээр мэдээллийг Говь ХК-ийн цахим хуудсанд нээлттэй байдлаар байршуулан тогтмол шинэчилдэг. • <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a> • <a href="#">Компанийн цахим хуудас дахь тайлан, үзүүлэлтүүд</a>		
ДҮН (Авбал зохих оноо-6)			6	100%	
<b>ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b>					
<b>ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана</b>					
15	<b>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Эрсдэл, аудитын хорооны үйл ажиллагааны журмын 3.1.3-д хөндлөнгийн аудитортой харилцах, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжоор хангах тухай тусгасан. Мөн тус хорооны зүгээс “Хараат бус аудитын компанид тавигдах шаардлага”-ыг баталсан бөгөөд тус шаардлагад үндэслэн ТУЗ-өөс “Хөндлөнгийн аудит томилох журам”-ыг баталсан. Эрсдэл, аудитын хороо нь дээрх журам, тогтоолуудын хэрэгжилтийг хангахаас гадна жил бүр хараат бус аудитын үйл ажиллагаанд нь хяналт тавин, аудитын төлөвлөгөө болон хараат бус аудиторын дүгнэлт, тайланг хэлэлцэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах тал дээр компанийн удирдлагуудад үүрэг даалгавар өгөн хяналт тавьж ажилладаг. • <a href="#">Эрсдэл, аудитын хорооны үйл ажиллагааны журам</a> • <a href="#">Хөндлөнгийн аудит томилох журам</a>	2	100%
16	<b>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Жил бүр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр хөндлөнгийн аудитын байгууллагаас төлөөллийг биечлэн оролцуулж, хувьцаа эзэмшигч нарыг хөндлөнгийн	2	100%

	<b>оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</b>		аудитораас асуулт асууж, мэдээлэл авах боломжоор ханган ажилладаг. <b>Хавсралт: 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл /Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн төлөөлөл Туслах менежер оролцсон тухай тусгасан./</b>		
17	<b>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Эрсдэл, аудитын хорооны шууд харьяалалд Дотоод аудитын хэлтэс ажилладаг. Жилийн үйл ажиллагааны тайланд дотоод аудитын тогтолцоо, бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан зэрэг мэдээллийг тусгадаг. Мөн компанийн цахим хуудсанд мэдээллийг байршуулсан байдаг. • <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a> -ийн 95-р нүүрэнд Дотоод хяналтын тогтолцоо, Дотоод хяналтын бодлогын талаар, 96-р нүүрэнд Дотоод аудитын хэлтсийн 2024 оны ажлын тайланг тусгасан.	2	100%
ДҮН (Авбал зохих оноо-6)				6	100%
<b>ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b>					
<b>ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина</b>					
18	<b>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Эрсдэл, аудитын хороо нь компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэн, хяналт тавьж ажилладаг. Тус хорооноос “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг 2023 онд шинэчлэн ТУЗ-өөр батлуулсан бөгөөд энэхүү бодлогын хүрээнд Гүйцэтгэх захирлын тушаалаар “Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-ыг баталсан. Эрсдэл, аудитын хороо нь дээрх бодлого, журмын хэрэгжилтийг нь хангуулан, хагас жил тутам хурлаараа дамжуулж хяналт тавин ажилладаг бөгөөд үр дүнг нь ТУЗ-ийн хурал дээр танилцуулдаг. • <a href="#">Эрсдэл, аудитын хорооны үйл ажиллагааны журам</a> • <a href="#">Эрсдэлийн удирдлагын бодлого</a>	2	100%

			<ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a>-ийн 97-р нүүрэнд Эрсдэлийн удирдлагын бодлогыг тусгасан.</li> </ul>		
19	<p><b>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давамжийн талаар тогтмол тайлагнана.</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>ТУЗ-өөс компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 2016 онд Аудитын хорооны чиг үүрэг дээр эрсдэлийн удирдлагыг хариуцах чиг үүргийг нэмэн Эрсдэл, аудитын хороо болгосон. Тус хороо нь 3 гишүүнтэйгээс 2 нь хараат бус гишүүн бөгөөд, хорооны даргаар мөн хараат бус гишүүн томилогддог. Эрсдэл, аудитын хороо нь хагас жил тутам компанийн эрсдэлийн удирдлагын багийн тайлантай танилцаж, компанийн хэмжээнд учирч болох эрсдэл болон түүнд авах хариу арга хэмжээний талаар хэлэлцэн, чиглүүлэг өгч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилладаг. Жилийн үйл ажиллагааны тайланд тус хорооны бүтэц бүрэлдэхүүн, ажлын тайлангаас гадна компанийн эрсдэлийн удирдлагын талаар мэдээ мэдээллийг тусган тайлагнадаг.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Эрсдэл, аудитын хорооны үйл ажиллагааны журам</a></li> <li>• <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a>-ийн 94-р нүүрэнд Эрсдэл, аудитын хорооны 2024 оны ажлын тайлан, 97-р нүүрэнд Эрсдэлийн удирдлагын бодлогыг тусгасан.</li> </ul>	2	100%
20	<p><b>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>Говь ХК-ийн ТУЗ нь 2024 онд “Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого” болон түүний хүрээнд “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого”, “Хүний эрх, жендерийн бодлого”, “Нийгмийн хариуцлагын бодлого”-уудыг шинээр баталсан.</p> <p>Бид жилийн үйл ажиллагааны тайландаа Тогтвортой хөгжил гэсэн бүлгийн хүрээнд байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагаатай холбоотой тайланг дэлгэрэнгүй тусган оруулдаг. Мөн 2021 оноос эхлэн МХБ-ээс боловсруулсан БОНЗ-ын тайлангийн</p>	2	100%

			<p>маягтын дагуу үнэлгээ хийн тайлан бэлтгэхээс гадна 2022 оноос Тогтвортой хөгжлийн тайланг тусад нь гаргаж эхэлсэн. Дээрх тайлангаа МХБ болон компанийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлдэг.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого</a></li> <li>• <a href="#">Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого</a></li> <li>• <a href="#">Хүний эрх, жендерийн бодлого</a></li> <li>• <a href="#">Нийгмийн хариуцлагын бодлого</a></li> <li>• <a href="#">БОНЗ-ын 2024 оны үнэлгээний тайлан</a></li> <li>• <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a>-ийн 48-67-р нүүрэнд Тогтвортой хөгжлийн удирдлага, Байгаль орчин, нийгмийн хариуцлагатай холбоотой мэдээлэл, 97-99-р нүүрэнд Эрсдэлийн удирдлагын талаарх тайлан, мэдээллийг тусгасан.</li> </ul>		
21	<p><b>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>Говь ХК нь байгууллагын дагаж мөрдөх шаардлагууд болон бусад үүрэг амлалтын нийцлийг удирдах замаар байгууллагын соёл, мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэх, компанийн хэмжээнд комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор 2021 онд Тогтвортой хөгжлийн хэлтсийн харьяалалд Комплайнсын нэгжийг үүсгэж Гүйцэтгэх захирлын тушаалаар Комплайнсын бодлогыг баталсан. Харин 2024 оноос эхлэн цар хүрээг нь улам өргөжүүлэн Комплайнсын газартай болсон бөгөөд Эрсдэл, аудитын хороо нь компанийн хэмжээнд комплайнсын хяналтыг давхар хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2024 оны 10-р сард Комплайнсын бодлогыг шинэчлэн баталсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Комплайнсын бодлого 2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a>-ийн 100-103-р нүүрэнд Комплайнсын удирдлагын тайланг тусгасан.</li> </ul>	2	100%
ДҮН (Авбал зохих оноо-8)				8	100%

<b>ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b>					
<b>Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна</b>					
22	<b>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>Говь ХК нь ТУЗ-ийн гишүүдийнхээ цалин урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ил тод хэлэлцэн баталдаг бөгөөд 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалинг шинэчлэн, цалингийн төсвийг баталсан.</p> <p>Мөн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын зарчим, хэмжээ, цалингийн төсвийн гүйцэтгэлийг жилийн үйл ажиллагааны тайланд ил тод тусгадаг.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a>-ийн 85-р нүүрэнд ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал, төсвийн гүйцэтгэл болон цалин, урамшууллын зарчмыг тусгасан.</li> <li>• <a href="#">2025 оны ХЭХ-ын тогтоол</a></li> </ul>	2	100%
23	<b>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>Цалин, урамшууллын хороо нь 2024 онд компанийн Цалин урамшууллын бодлогыг шинэчлэн ТУЗ-өөр батлуулсан.</p> <p>Мөн <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a>-ийн 93-р нүүрэнд Цалин урамшууллын бодлогыг тусгасан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Цалин урамшууллын бодлого</a></li> </ul>	2	100%
24	<b>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>Жилийн үйл ажиллагааны тайланд Гүйцэтгэх захирал болон Менежмент багийн удирдлагуудын цалин урамшууллын бүтэц, зарчим ажлын үр дүнг дүгнэх үзүүлэлт зэрэг мэдээллийг тусгадаг.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a>-ийн 109-110-р нүүрэнд Менежмент багийн удирдлагуудын цалин, урамшууллын мэдээллийг тусгасан.</li> </ul>	2	100%
<b>ДҮН (Авбал зохих оноо-6)</b>				<b>6</b>	<b>100%</b>

<b>ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ</b>					
<b>Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ</b>					
25	<b>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>Говь ХК нь үйл ажиллагаандаа бүхий л оролцогч талуудын эрх ашгийг хангах тал дээр анхааран ажилладаг бөгөөд энэ талаар Засаглалын бодлого болон Ёс зүйн коддоо тусгасан байдаг.</p> <p>Гүйцэтгэх захирлын тушаалаар “Оролцогч талуудын өргөдөл, санал гомдол хүлээн авах шийдвэрлэх журам”-ыг батлан хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.</p> <p>Мөн ТУЗ-өөс “Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө”-г 2023 онд баталсан бөгөөд Жилийн үйл ажиллагааны тайланд холбогдох мэдээллийг тусгасан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Засаглалын бодлого</a></li> <li>• <a href="#">Ёс зүйн код</a></li> <li>• <a href="#">Оролцогч талуудын өргөдөл, санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам</a></li> <li>• <a href="#">Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө</a></li> </ul>	2	100%
26	<b>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>Жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтын ажиллагааны талаарх мэдээллийг тусгадаг бөгөөд хувьцаа эзэмшигч, харилцагч болон олон нийт гэх мэт бүхий л оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцэхүйц агуулгаар санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тусган, жил бүр агуулгаа сайжруулдаг.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a>-ийн 73-75-р нүүрэнд Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөөтэй холбоотой мэдээллийг тусгасан.</li> </ul>	2	100%
27	<b>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>Компанийн цахим хуудсанд хувьцаа эзэмшигч нар болон олон нийтэд зориулсан компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг нийтлэн, агуулгыг нь тогтмол шинэчлэн ажилладаг. Мөн оролцогч талуудтай хамтран</p>	2	100%



	<b>компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</b>		ажиллах саналыг зарлах, тэдгээрээс санал хүсэлт хүлээн авах цэстэй бөгөөд санал хүсэлтийг нь тогтмол хүлээн авч эргэх холбоотой ажилладаг. <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Компанийн цахим хуудас дахь санал хүсэлт хүлээн авах цэс</a></li> <li>• <a href="#">Компанийн цахим хуудас</a></li> </ul>		
28	<b>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	“Оролцогч талуудын өргөдөл, санал гомдол хүлээн авах шийдвэрлэх журам”-д ажилтнуудаас ирсэн санал гомдлыг хэрхэн хүлээн авч, шийдвэрлэх талаар тусгасан байдаг. Мөн ажилтнуудаа сургаж хөгжүүлэн мэргэжил дээшлүүлэх асуудлыг “Сургалт хөгжлийн журам”-аар зохицуулдаг бөгөөд жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажилладаг. Ажилтнуудын нийгмийн асуудлыг үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан хамтын гэрээний дагуу шийдвэрлэн, хэрэгжилтийн тайлангаар дүгнэн сайжруулалт хийдэг. <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Оролцогч талуудын өргөдөл, санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам</a></li> </ul>	2	100%
ДҮН (Авбал зохих оноо-8)				8	100%
<b>НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ</b>					
<b>ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно</b>					
29	<b>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-өөс “Ёс зүйн код”-ыг баталсан бөгөөд компанийн цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлсэн. Энэхүү “Ёс зүйн код”-д компанийн ёс зүйн зарчим болон ТУЗ-ийн гишүүд, удирдлагын баг, нийт ажилтнуудын баримтлах ёс зүйн хэм хэмжээг тодорхой тусгасан байдаг. <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Ёс зүйн код</a></li> </ul>	2	100%
30	<b>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь 2022 оноос эхлэн компанийн хэмжээнд илэрсэн ёс зүйн зөрчлийг хүлээн авч, шийдвэрлэх, хяналтыг хэрэгжүүлэх зорилготой “Шүгэл үлээх удирдлагын тогтолцоо”-г хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн	2	100%

	<b>мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</b>		жилийн тайланд үр дүнг нь тусган тайлагнадаг. <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам</a></li> <li>• <a href="#">Компанийн шүгэл үлээх систем</a></li> <li>• <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан</a>-ийн 102-103-р нүүрэнд Шүгэл үлээх удирдлагын тогтолцоотой холбоотой мэдээллийг тусгасан.</li> </ul>		
31	<b>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь “Ёс зүйн код”-доо ашиг сонирхлын зөрчил, авлига, хээл хахуулиас ангид хуулийн хүрээнд ажиллах тухай болон засгийн газар, улс төр, шашны харилцааны талаар баримтлах зарчмуудыг тусган оруулсан байдаг. Энэхүү зарчмуудынхаа дагуу авлига албан тушаалын зөрчлөөс сэргийлэх, хандив, бэлэг дурсгал өгөх болон хүлээн авах зохицуулалтыг хийдэг. Мөн ТУЗ-өөс 2023 онд “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Ёс зүйн код</a></li> <li>• <a href="#">Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам</a></li> </ul>	2	100%
ДҮН (Авбал зохих оноо-6)				6	100%
<b>ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</b>					
<b>Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана</b>					
32	<b>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь “Олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ынхаа хэрэгжилтийг ханган оролцогч талуудад хүргэх хугацаат болон тухай бүр мэдээлэх мэдээллүүдийг МХБ болон компанийн цахим хуудсаар дамжуулан хугацаанд нь мэдээлдэг. Мөн компанийн цахим хуудасны бүтэц, агуулгаа тогтмол шинэчлэн “Хувьцаа эзэмшигчдэд” гэсэн цэсээр дамжуулан оролцогч талуудад компанийн санхүү болон үйл ажиллагаатай холбоотой тайлан, цаг үеийн мэдээ мэдээлэл, бодлого журмуудаа нээлттэйгээр мэдээлэн ажилладаг.	2	100%

			Бид 2024 оноос эхлэн олон нийтэд хүргэх тайлан, мэдээллүүдийг англи хэл дээр давхар бэлтгэн хүргэж байна. <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Олон нийтэд хүргэх мэдээллийн журам</a></li> <li>• <a href="#">Компанийн цахим хуудас /англи/</a></li> </ul>		
33	<b>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь 2023 онд “Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр”-ийг баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд хувьцаа эзэмшигч нарынхаа оролцоог хангах зорилгоор үйлдвэртэй танилцах аяллыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж байна. Компанийн цахим хуудсаараа дамжуулан хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нартаа компанийн тухай мэдээ мэдээллийг тухай бүр хүргэхээс гадна санал хүсэлтийг нь нээлттэй хүлээн авч, шийдвэрлэн, хариу өгч ажилладаг. <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр</a></li> <li>• <a href="#">Компанийн цахим хуудас дахь санал хүсэлт хүлээн авах цэс</a></li> <li>• <a href="#">Компанийн цахим хуудас</a></li> </ul>	2	100%
34	<b>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК-ийн ТУЗ-өөс “Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам”-ыг баталсан. Энэхүү журмаар хувьцаа эзэмшигчдийн зүгээс хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах, хуралд оролцох, санал өгөх зэрэг эрхээ хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигч нарт хурлын зарыг хүргэх, ХЭХ-ыг зохион байгуулахтай холбоотой бүхий л харилцааг зохицуулсан байдаг ба хэрэгжилтийг нь ханган ажилладаг. <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам</a></li> </ul>	2	100%
35	<b>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Говь ХК нь хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийг хүндэтгэн, Компанийн тухай хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх боломжоор нь хангахад анхаарч, аливаа шийдвэрийг гаргахдаа засаглалын сайн зарчмыг баримтлан ажилладаг. <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр</a></li> </ul>	2	100%

			<ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Компанийн цахим хуудас дахь санал хүсэлт хүлээн авах цэс</a></li> </ul>		
36	<p><b>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</b></p>	Бүрэн хэрэгжүүлсэн.	<p>Говь ХК-ийн ТУЗ нь 2023 онд “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ыг баталсан бөгөөд жил бүрийн эхний ТУЗ-ийн хурал дээр тухайн жилд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх холбоотой талын компаниуд жагсаалт болон холбогдох төсвийг баталж, улирал бүр Эрсдэл, аудитын хорооны хурлаар сонирхлын зөрчилтэй хэлцлийн гүйцэтгэлтэй танилцан, хяналт тавьдаг. Мөн жилийн үйл ажиллагааны тайланд холбоотой талуудтай хийгдсэн сонирхлын зөрчилтэй гүйлгээний тайлан болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн мэдээллийг нийтэлж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр Эрсдэл, аудитын хорооны зүгээс гүйцэтгэлийг нь танилцуулдаг. Мөн сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээ, тайлбар, холбогдох шийдвэрийг МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэхээс гадна улирал бүр СЗХ руу давхар хүргэж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан-ийн 27-29-р нүүрэнд Их хэмжээний болон Сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг тусгасан.</a></li> <li>• <a href="#">2025 онд сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийгдэх хэлцэлд зөвшөөрөл олгох тухай ТУЗ-ийн тогтоол</a></li> <li>• <a href="#">Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам</a></li> </ul>	2	100%
ДҮН (Авбал зохих оноо-10)				10	100%
НЭГДСЭН ДҮН (Авбал зохих оноо-72)				71	98.6%

## НОТЛОХ БАРИМТЫН ЖАГСААЛТ

### Линкээр оруулсан нотлох баримтууд

1. [Засаглалын бодлого](#)
2. [Дотоод хяналтын бодлого](#)
3. [Эрсдэлийн удирдлагын бодлого](#)
4. [ЭБАТ-уудын залгамж халааны бодлого](#)
5. [Цалин урамшууллын бодлого](#)
6. [Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого](#)
7. [Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого](#)
8. [Хүний эрх, жендерийн бодлого](#)
9. [Нийгмийн хариуцлагын бодлого](#)
10. [Комплайнсын бодлого](#)
11. [Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам](#)
12. [ТУЗ-ийн үйл ажиллагааны журам](#)
13. [ТУЗ-ийн ажлын албаны журам](#)
14. [Эрсдэл, аудитын хорооны үйл ажиллагааны журам](#)
15. [Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам](#)
16. [Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам](#)
17. [ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам](#)
18. [Олон нийтэд хүргэх мэдээллийн журам](#)
19. [Хөндлөнгийн аудит томилох журам](#)
20. [Ёс зүйн код](#)
21. [Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам](#)
22. [Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам](#)
23. [Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр](#)
24. [Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр](#)
25. [Оролцогч талуудын өргөдөл, санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам](#)
26. [Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө](#)
27. [Компанийн цахим хуудас /info.gobi.mn/](#)
28. [Компанийн цахим хуудас дахь дүрэм журмууд](#)
29. [Компанийн цахим хуудас дахь тайлан, үзүүлэлтүүд](#)
30. [Компанийн цахим хуудас дахь санал хүсэлт хүлээн авах цэс](#)
31. [Компанийн шүгэл үлээх систем](#)
32. [2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан](#)
33. [БОНЗ-ын 2024 оны үнэлгээний тайлан](#)
34. [2025 онд сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийгдэх хэлцэлд зөвшөөрөл олгох тухай ТУЗ-ийн тогтоол](#)
35. [2025 оны ХЭХ-ын тогтоол](#)
36. [ТУЗ-ийн дарга болон хороодын бүрэлдэхүүнийг томилсон ТУЗ-ийн тогтоол](#)

“Говь ХК”, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул  
Дүүрэг, Улаанбаатар-17062, Монгол Улс, Ш/Х 36/434

Утас: +976 7013-9977, Факс: +976 7014-3081  
И-мэйл: [info@gobi.mn](mailto:info@gobi.mn)